



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ
ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН
ЗАХИРАМЖ

2024 07 01
оны сарын өдөр

115/ШЗ2024/0058
Дугаар

Сайншанд сум

Хүсэлт шийдвэрлэж, захиргааны актын
биелэлтийг түдгэлзүүлэх тухай

Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Сийлэгмаа удирдаж, нэхэмжлэгч “Саммитмедикал сервис” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Халиун, С.Балжинням нар цахимаар, хариуцагч Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Энх-Амгалан, гуравдагч этгээд “Сетунари” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Бямбажаргал, М.Мягмарсүрэн, шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар Г.Ууганзулыг оролцуулан явуулсан шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр, нэхэмжлэгч хуулийн этгээдээс гаргасан “Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай” хүсэлтийг хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч “Саммитмедикал сервис” ХХК-ийн шүүхэд бичгээр ирүүлсэн хүсэлт болон итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөс шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт гаргасан тайлбарт: Манай компаниас Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгээс ДГАНЭ/202311005/02/01 дугаартай “Компьютер томографын аппарат худалдан авах тендер сонгон шалгаруулалтын ажиллагааг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дахин зарласан шийдвэрийг хүчингүй болгуулахаар нэхэмжлэл гарган, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа билээ.

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгээс Сангийн яаманд гомдол гаргасан талаар хугацаандаа мэдэгдээгүйн улмаас манай компани захиалагчийн 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн 173 тоот “Гэрээ байгуулах эрх олгох тухай” мэдэгдлийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1 дэх хэсэгт заасны дагуу ажлын 6 хоног хүлээгээд, 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр тендерийн баримт бичигт заагдсан 99510203 дугаартай утас руу залгаж тендер шалгаруулалттай холбоотой санал гомдол гарсан талаар лавлаад, “гомдол гарсан мэдээлэл алга байна” гэсэн мэдээлэлд үндэслэж 2024 оны 03 сарын 26-ны өдөр тендерийн гүйцэтгэлийн баталгаа болох 83,400,000 төгрөгийг Худалдаа хөгжлийн банканд байршуулж, энэ тухайгаа захиалагчид албан ёсоор мэдэгдсэн.

Тухайн өдрөө Компьютер томографын аппарат нийлүүлэх гэрээнд манай компанийн талаас бүх мэдээллийг оруулан захиалагчид илгээсэн ба эх хувийг баталгаажуулж Монгол шуудангаар илгээсэн.

Мөн тус тендерийн гүйцэтгэлийг түргэн шуурхай гүйцэтгэхийн тулд манай компанийн зүгээс үйлдвэрлэгч болох PHILIPS компани руу компьютер томографын аппаратын үйлдвэрлэлийг эхлүүлэх зорилгоор 2024 оны 03 сарын 26-ны өдөр урьдчилгаа төлбөр болох 33,130.50 еврог шилжүүлээд аппаратын үйлдвэрлэлийг эхлүүлсэн. Нэгэнт үйлдвэрлэл эхэлсэн тул тус урьдчилгаа төлбөрийг манай компани буцаан авах боломжгүй нөхцөл байдал үүсэж бидний эрх, ашиг хөндөгдөж, бид санхүүгийн эрсдэлд орох нөхцөл байдал үүссэн.

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгээс “Компьютер томографын аппарат худалдан авах тендер сонгон шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дахин зарласан. Тус тендер шалгаруулалтын ажиллагаа нь үргэлжилж 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр нээлтээ хийхээр цахим хуудаст мэдээлэл орсон байна. Хэрэв дээрх тендер сонгон шалгаруулалт явагдсан тохиолдолд манай компанийн тус шүүхэд нэхэмжлэл гарган маргаж буй асуудал ач холбогдолгүй болох бөгөөд манай компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхол сэргэх боломжгүйд хүрэхээр байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Энэ хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ” гэж заасны дагуу Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгээс, 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дахин зарласан Компьютер томографын аппарат худалдан авах тендер сонгон шалгаруулалтын ажиллагааг тус хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаагаар түдгэлзүүлж өгөхийг хүсье. Энэ тохиолдолд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал байхгүй бөгөөд харин захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлснээр нэхэмжлэгчид урьдчилсан хамгаалалт бий болохоор байгаа болно.

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхтэй холбоотойгоор Улсын дээд шүүхээс захиргааны хэргийн биелэлтийг түдгэлзүүлэх журам 62,61 дугаартай тайлбар гаргасан. Энэ тайлбар дээр юу гэж байна вэ? гэхээр нийтийн ашиг сонирхол эргэн сэргээх боломжгүй эсвэл сөрөг үр дагавар бий болсон байх юм бол түдгэлзүүлж болохгүй гэдэг зүйл байгаа. Гэтэл тендер шалгаруулалтыг түдгэлзүүлснээр нийтийн ашиг сонирхол эргэж сэргэхгүй нөхцөл байдал байхгүй. Энэ тендер шалгаруулалтын хувьд удаан үргэлжилж байна. Бид нар ч гэсэн энэ хэргийг удаан үргэлжлүүлээд иргэдийн эрх, ашгийг зөрчөөд байгаа сонирхол байхгүй гэв.

Хариуцагч Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн шүүхэд бичгээр ирүүлсэн тайлбар болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт гаргасан тайлбарт: “Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажил”-ын ДГАНЭ/202311005 дугаартай тендер шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зарласан шийдвэрийн

биелэлтийг түдгэлзүүлэх тухай “Саммитмедикал сервис” ХХК-ийн хүсэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр зарласан компьютер томографын аппарат худалдан авах тендертэй холбоотой Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 173 тоот “Гэрээ байгуулах эрх олгох тухай” шийдвэрт тендерт оролцогч “Сетунари” ХХК-иас гомдол гаргаж, Сангийн яамнаас тухайн худалдан авах ажиллагааг түдгэлзүүлсэн талаар 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 03/1989 тоот албан бичиг ирүүлсний дагуу гэрээ эцэслэн байгуултал тодорхой ажиллагаа хийж гүйцэтгэлгүй, түр хүлээхийг “Саммитмедикал сервис” ХХК-д захиалагчаас бүх талаар мэдээлж, тус тендер шалгаруулалтын ажиллагааны талаар цахим хуудаст мэдээлэл оруулж байсан.

“Саммитмедикал сервис” ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон захиалагчийн шийдвэрийг Сангийн яамны 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 03/2353 дугаар шийдвэрээр хүчингүй болгосон. Энэ шийдвэр хүчингүй болсон тухай эрх бүхий байгууллагын аливаа шийдвэр, мэдэгдэл бидэнд ирээгүй, шийдвэр хүчин төгөлдөр байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь заалтад “Захиалагч доор дурдсанаас бусад тохиолдолд шалгарсан оролцогчтой гэрээ байгуулна” гэж, 30.3.2-т “энэ хуульд заасан гомдол хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага, эсхүл шүүхийн шийдвэрээр тендер шалгаруулалтыг түдгэлзүүлсэн, гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгосон, эсхүл тендер шалгаруулалтыг хүчингүйд тооцсон” гэж заасан.

Тиймээс өмнөх 2023 оны тендерт аль ч оролцогч шалгараагүй, “Саммитмедикал сервис” ХХК-тай гэрээ эцэслэн байгуулагдаагүй, гэрээ байгуулах эрх олгосон захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгосон учир бид гэрээ байгуулах боломжгүй, тус компанитай гэрээ байгуулагдаагүйд захиалагч талаас шалтгаалсан зүйл огт байхгүй. “Саммитмедикал сервис” ХХК нь гэрээ эцэслэн байгуулагдаагүй байхад тендерийн гүйцэтгэлийг хугацаанд нь түргэн шуурхай гүйцэтгэхийн тулд үйлдвэрлэгч компани руу компьютер томографын аппаратын үйлдвэрлэлийг эхлүүлэх зорилгоор 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр урьдчилгаа төлбөр төлсөн гэжээ. Иймд Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгээс 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр тендерийг дахин зарласантай огт хамааралгүй дээрх асуудлаар тус компани нь эрх, ашиг хөндөгдсөн гэж тендер шалгаруулалтыг зогсоолгох хүсэлт гаргасан нь үндэслэлгүй.

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгээс 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дахин зарласан тендер нь орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор сонгон шалгаруулалтад шаардлага хангасан хэн ч оролцох боломжтой байхаар нийтэд зарласан, нэхэмжлэгч “Саммитмедикал сервис” ХХК нь тус тендерт оролцож байх тул тендер зарласан шийдвэр нь тус компанийн эрх, ашиг сонирхлыг хөндөхгүй, зөрчихгүй, хөндөгдөх, зөрчигдөх эрх, ашиг сонирхол “Саммитмедикал сервис” ХХК-д үүсээгүй байна.

Харин тус тендерийг зарласан шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх, мөн тус тендер сонгон шалгаруулалтын ажиллагааг хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх тохиолдолд Нэгдсэн эмнэлэг тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөө худалдан авч чадахгүй, үүний үр дүнд аймаг орон нутагтаа компьютер томографын оношилгоо хийлгэх боломжгүй, иргэдийн эрүүл мэнд, амь нас зэрэг нийтийн эрх ашиг сонирхлыг эргэж сэргээх боломжгүйгээр хохироохуйц сөрөг үр дагавар бодитоор бий болгож байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалтад “Сонирхогч этгээд, эсхүл оролцогч гомдол хянан шийдвэрлэх байгууллагын, эсхүл худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно” гэж, 60.2 дахь заалтад “Энэ хуулийн 59.2-т зааснаар урьдчилан шийдвэрлүүлэх журмаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гомдол хянан шийдвэрлэхээс бусад тохиолдолд худалдан авах гэрээ байгуулснаас хойш гаргасан гомдлыг шүүхэд гаргана” гэж заасан.

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дахин тендер зарласан шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлага нь дээрх хуульд заасан шүүхэд хандах үндэслэлийн алинд ч хамаарахгүй байна. Иймд тендер дахин зарласан захиалагчийн шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх, тендер сонгон шалгаруулалтыг зогсоох нэхэмжлэгчийн хүсэлт нь үндэслэлгүй бөгөөд захиалагчийн шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх нь нийтийн ашиг сонирхолд илтэд хохиролтой захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал байх тул нэхэмжлэгчийн хүсэлтийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, захиргааны шийдвэр болон тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг хэвээр үлдээж өгнө үү.

Тухайн компьютер томографын аппарат худалдаж авах ажил нь аливаа нэг компанийн эрх ашгийн асуудлаас илүүтэйгээр тухайн орон нутгийн иргэд болоод цаашлаад энэ нутаг орноор зорчдог иргэдийн эрүүл мэндийн асуудал, амь насны асуудалтай шууд холбоотой асуудал байгаа. Тэгэхээр компьютер томографын аппаратыг худалдаж авах ажиллагааг түдгэлзүүлэлгүйгээр цааш үргэлжлүүлэх нь тухайн иргэдийн амь нас, эрүүл мэндийн асуудалтай шууд хамааралтай учраас нэн тэргүүнд тавьж авч үзээсэй гэж хүсэж байна. Мөн тендерт оролцож байгаа оролцогч компаниудаас хууль хяналтын болон бусад хуульд заасан эрх бүхий байгууллагуудад гомдол гаргаж байгаа, үндэслэлтэй болон үндэслэлгүй асуудлаар гомдол гаргаж байгаа энэ асуудлууд нь тухайн худалдан авах ажиллагааг удаашруулсан, иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхийг хөндсөн, зөрчсөн ийм асуудал болоод байна. Иймд түдгэлзүүлэх асуудлыг буюу хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж өгнө үү гэж хүсэж байна гэв.

Гуравдагч этгээд “Сетунари” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нараас шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт гаргасан тайлбарт: Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 3 дугаар сарын 18-ны өдрийн 173 дугаар дугаартай гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлээр талуудын хооронд гэрээ байгуулагдсан гэж үзэхгүй. Гэрээ байгуулагдаагүй байхад урьдчилгаа төлбөр төлсөн, нэгэнт үйлдвэрлэл эхэлсэн тул урьдчилгаа төлбөрийг буцаан авах боломжгүй гэж үзэж байгаа нь өөрөө

үндэслэлгүй. Үүгээр дахин тендер сонгон шалгаруулалт явагдсан тохиолдолд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол сэргэх боломжгүй гэж байгаа нь өөрөө үндэслэлгүй, нэхэмжлэгчид хууль ёсны эрх, ашиг сонирхол үүсээгүй буюу актын биелэлтийг түдгэлзүүлэх ерөнхий нөхцөл бий болоогүй. Гэрээ байгуулагдаагүй гэдэг нь гэрээ байгуулах нөхцөл чинь 2 тал хоорондоо гэрээ байгуулаад гарын үсэг зураад сая хүчин төгөлдөр болсноор тэр гэрээний үүргийг шаарддаг нөхцөлтэй. 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулагдах эрх нээгдээгүй байсан гэж би ойлгоод байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1-д зааснаар 6-с доошгүй хоногийн дараа гэрээ байгуулагдах эрх нээгддэг. Энэ нь өөрөө 3 дугаар сарын 27-ны өдөр байгаа. Гэтэл 3 дугаар сарын 27-ны өдрөөс цахим дээр түдгэлзүүлсэн төлөв рүү орсон. Гомдол гарсан төлөв рүү орсон. Цахимд гомдол гарсан төлөв рүү орчихсон байж байхад эднийх яагаад 3 дугаар сарын 26-ны өдөр буюу 1 өдрийн өмнө гэрээгээ явуулсан гээд байдаг юм. Нийслэлийн захиргааны хэргийн шүүх дээр дандаа цахим баримт байдаг. Гэрээг бид нар дандаа цаасаар албажуулаад явуулдаг. Танайх яагаад и-мэйлээр явуулсан юм. Тэр их сонин, и-мэйлээр явуулснаа өнөөдөр гэрээ байгуулагдсан гээд зөвхөн гэрээгээ явуулсныгаа та нар гэрээ байгуулагдсан гэж үзэж бас болохгүй.

Бид нар хохирчхоод байна гэж нотлох баримтаар өгөөд байгаа. Тэр бүхэн чинь өөрөө энэ актын биелэлтэд хамааралгүй эрх, ашиг хөндөгдөхгүй. Яагаад гэвэл 1 дүгээрт гэрээ байгуулагдаагүй, гэрээ байгуулах нөхцөл чинь 3 дугаар сарын 27-ны өдрөөс эхэлж үүснэ. Танай төлбөр төлсөнтэй гэрээ байгуулсан нөхцөл хамаагүй. Гэрээ байгуулагдах хуулийн хугацаа болоогүй, гэрээ байгуулах нөхцөл боломжгүй, урьдчилсан нөхцөл биелэлт бүрдээгүй байхад гэрээний үүрэг шаардаж, тэрийгээ хохирол учирсан үр дагавар гэж захиргааны акттай холбож тайлбарлаж байгаа нь өөрөө үндэслэлгүй. Өөрөөр хэлбэл хүсэлтийнхээ үндэслэлээ эднийх ингэж тайлбарлаад байгаа. Бид нар түргэн шуурхай үүргээ гүйцэтгэхийн тулд барааныхаа төлбөрийг үйлдвэрлэгч рүүгээ төлчихсөн гэж. Гол үндэслэлээ актын биелэлтийг түдгэлзүүлбэл болохгүй, бид нарын эрх ашиг зөрчигдөх гээд байна, хохирох гээд байна гээд байгаа үндэслэл нь өөрөө үйлдвэрлэгч рүү бараа захиалсныгаа хэлээд байна гэж ойлгож байна.

Эмнэлгийн тоног төхөөрөмж, нэн ялангуяа эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хувьд хүний эрүүл мэнд, амь нас гэдэг зүйлтэй салшгүй холбоотой байдаг. Тэр амь нас аврах, эрүүл мэндэд нь тусламж үзүүлэх тэр хэрэгцээ шаардлагын хүрээнд өнөөдөр, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж гэдэг зүйлийг эмнэлэг худалдаж авдаг. Тийм байхад өнөөдөр худалдан авах ажиллагааг зогсоож өгөөч гэж хүсэлт гаргаж байгаа нь өөрөө хүнлэг бус.

Дорноговь аймгийн иргэд гэдэг бол маш олон хүмүүс байгаа бөгөөд аймгийн хүн амын эрүүл мэндийн асуудлыг бид нар ярьж байна. Нийтийн эрх, ашиг хөндөгдөж байна, нийтийн эрх ашиг хөндөгдөж байгаа ийм үед зөвхөн манайхыг шалгаруулах байсан юм, миний эрх ашиг хөндөгдөх гээд байна? гээд өнөөдөр тендерт нь оролцоод явж байгаа хэрнээ миний эрх, ашиг хөндөгдөж байна гээд, хөндөгдөж байгаа гэдэг эрх ашиг нь өөрөө сайн дураар үйлдвэрлэгч рүүгээ мөнгөө

төлсөн болохоос биш одоо захиалагчаас шалтгаалаад төлбөр төлчихсөн асуудал биш, тэрэнтэй цаг хугацааны хувьд ч хамааралгүй, гэрээ байгуулагдаагүй, хуульд заасан урьдчилсан нөхцөлүүд ч бүрдээгүй, хувь гэрээ нь ч байгуулагдаагүй учраас хэлж байна.

Саммитийн хэлж байгаа үндэслэл бол хууль зүйн үндэслэлгүй, баримтгүй, шалтгаант холбоогүй, цаг хугацааны хувьд ч гэсэн хуульд заасан хугацаанаас өмнө сайн дураар гүйцэтгэсэн захиалагчаас хамааралгүй зүйл. Нөгөө талаас өнөөдөр тендер зогсоогоод өгөөч гээд миний эрхийн хамгаалалт үүсэх юм гээд байгаа нь өөрөө бас үндэслэлгүй гэж үзэж байна. Яагаад гэвэл Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль байдаг. Хуулийн 60 дугаар зүйл дээр юу байдаг вэ? гэхээр төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой ямар тохиолдолд нэхэмжлэл гаргах юм бэ? ямар хүрээнд гаргах вэ, ямар тохиолдолд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх юм бэ? гэдэг нөхцөл байдлуудыг 60 дугаар зүйл дээр нь 4 заалтаар зохицуулсан байдаг. 60.1 дээр сонирхогч этгээд эсвэл оролцогч гомдол хянан шийдвэрлэх байгууллагын худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдлоо гаргаж болно гэж байгаа. Энд гомдол хянан шийдвэрлэх байгууллага гэдэг нь Сангийн яамыг хэлж байгаа болохоос биш захиалагчид гомдол гаргаж шүүхэд хандана гэсэн зохицуулалт байхгүй. 60.2 энэ хуулийн 59.2-т зааснаар урьдчилан шийдвэрлэх журмаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдол хянан шийдвэрлэхээс бусад тохиолдолд худалдан авах гэрээ байгуулснаас хойш гарсан гомдлыг шүүхэд гаргана. Энд гэрээ байгуулах процесс явагдаагүй байгаа. Тийм учраас шүүхэд гаргах үндэслэл өөрөө мөн үү? гэдэг нь эргэлзээтэй байна.

Яагаад гэвэл 4 дүгээр сарын 23-ны өдөр тендер зарласан процесс нь шүүхэд сонирхогч этгээд, оролцогчийн шүүхэд гомдол гаргах үндэслэлд аль алинд нь ч хамаарахгүй байна. 60.3 дээр шүүх захиалагчийн шийдвэр, худалдан авах ажиллагааны гэрээний биелэлтийг түдгэлзүүлэх нь нийтийн ашиг сонирхолд илтэд хохиролтой гэж үзсэнээс бусад тохиолдолд түдгэлзүүлэх эсэхийг шийдэхээр байгаа. Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ гэдэг хүний эрүүл мэнд, амь настай холбоотой, нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлж болох, хохирол учруулж болох ийм нөхцөл байдал байдаг учраас нийтэд илтэд хохиролтой зүйлийг зогсоохоор нэхэмжлэл гаргаж байгаа нь өөрөө үндэслэлгүй бөгөөд маш хүнлэг бус гэдгийг онцлоод хэлчихье. Тийм учраас нэхэмжлэгчийн гаргаж байгаа хүсэлт нь хууль зүйн үндэслэлгүй, өөрийнх нь эрх, ашиг хөндөгдөөгүй, одоо ч өөрөө үргэлжлүүлээд тендерт ороод явж байгаа. Эсрэгээрээ энэ актын биелэлтийг түдгэлзүүлэх тохиолдолд аймгийн хүн ам, иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээ авч чадахгүй, хор хохирол учруулахаар, нийтийн эрх, ашиг сонирхол хөндөгдөхөөр байгаа тул энэ нөхцөл байдлыг шүүгч харгалзаж үзээд нэхэмжлэгчийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгож өгөөч гэсэн тайлбарыг өгч байна гэв.

Сая нэхэмжлэгчээс гаргасан тайлбар болон хариуцагчийн тайлбар, мөн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс гаргасан тайлбар дээр давхцахгүйгээр хариу тайлбар хэлье. Захиргааны актыг биелэлтийг түдгэлзүүлэх арга хэрэгслийн зорилго нь өөрөө нэхэмжлэгчид эрх зүйн урьдчилсан хамгаалалт үзүүлэх зайлшгүй бөгөөд бодит

үндэслэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бий болсон байхыг шаарддаг. Гэтэл маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлснээр нэхэмжлэгчийн яг ямар зөрчигдсэн эрхэд хамгаалалт тогтоож буй нь тодорхойгүй байгаа бөгөөд энэ нь өөрөө эрх зүйн хамгаалал, үр нөлөөтэй байх зарчимд нийцэхгүй байна гэж харж байна. Нөгөө талаас нэхэмжлэгч "Саммитмедикал" ХХК-ийн хувьд сая урьдчилгаа төлбөр шилжүүлсэн гэсэн юм яриад байна. Энэ нь өөрөө эрх зүйн хамгаалалтын өөр арга хэрэгсэл дууссан гэж дүгнэх ерөөсөө боломжгүй байна. Учир нь урьдчилгаа төлбөр шилжүүлсэн гэж байгаа. Нэхэмжлэгчийн гэм хор нь өөрөө иргэний эрх зүйн журмаар хамгаалалт хэрэгжүүлэх, энэ талаараа бодит эрх бүхий хамгаалалт, эрхээ эдлэх нээлттэй хэвээрээ байгаа, дууссан гэж үзэхгүй байна. Яагаад гэхээр "Саммит медикал сервис" нь сая банкны дансны хуулгыг нь харсан чинь яг л гэрээний эрх зүйн харилцаанд гадаадын хуулийн этгээдтэй гэрээ байгуулчихсан, тэрэндээ урьдчилгаа төлбөр шилжүүлчихсэн. Гэрээ байгуулагдаагүй байхад яараад сайн дураараа түргэн шуурхай гүйцэтгэх тухай зарчим Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд байдаггүй. 5 дугаар зүйлийг харвал хариуцлагатай буюу тэгш эрхээр хангагдсан байх зарчим л үйлчилдэг гэж заасан байгаа. Тэгэхэд өөрсдөө хариу тайлбартаа хэлэхдээ бид нар түргэн байх зарчмыг баримталсан гээд үндэслэлгүй тайлбар хэлээд байна. Тэгэхлээр энэ маань өөрт учирсан хохирлоо иргэний эрх зүйн журмаар тэр хамгаалалтаа өөрөө хэрэгжүүлээд явах эрх нь нээлттэй байна.

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд жингийн туухайн дээр тавиад үзэхэд нэг талд нь Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлэх, тэр томографыг ашиглах, эрүүл мэндийн үйлчилгээ авахаар жагсаж байгаа хэчнээн өвчтөн байгаа вэ? Өнөөдөр бид хоёр гуравдагч этгээдийг төлөөлөөд орж ирж байгаа. Цаана нь өнөөдөр тендер шалгаруулалтад оролцож байгаа бараг 10 гаруй компани байгаа энэ хүмүүсийг жингийн туухай дээр тавиад үзэх юм бол зөвхөн "Саммитмедикал" ХХК-ийн урьдчилгаа төлбөрийн мөнгөний асуудал яригдаж байна. Энэ 2-ыг харьцуулж шүүгч харгалзаж үзээсэй.

Гэрээ огт байгуулагдаагүй байхад гэрээний үүргээ сайн дурын үндсэн дээр биелүүлсэн тохиолдолд иргэний эрх зүйн зарчмаараа энэ хариуцлагаа өөрөө хүлээдэг ийм зарчимтай. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх зохицуулалт нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5 дахь заалтаар зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон байх зарчим буюу харьцангуй тэнцвэртэй байх зарчимтай шууд өөрөө холбогддог. Өөрөөр хэлбэл захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд эрх олгох, эсхүл эрхийг хязгаарлах тохиолдолд тодорхой зорилготой байх ёстой. Бодит нөхцөлд тохирсон, зохистой хэм хэмжээ хязгаартай байх ёстой. Энэ зарчмын үүднээс хуулиар хамгаалсан үнэт зүйл, эрх, хууль ёсны ашиг сонирхлын хооронд өрсөлдсөн шинжтэй зөрчилдөөн үүсвэл шүүх жинлэж, улмаар аль эрх, хууль ёсны ашиг сонирхол нь эн тэргүүнд авч хамгаалахыг нь зүй тогтоодог ийм зарчим үйлчилдэг. Тэгэхээр аль эрх хууль ёсны ашиг сонирхлыг эн тэргүүнд авч үзэх юм бэ? гэхээр энэ талд байгаа Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлэх, тухайн томографар эмчлүүлэх хэдэн 10 өвчтөн, тэнд байгаа эмч нар, сувилагч нар мэргэших гээд байж байгаа. Тэд ажлын байраар хангагдах, энд өрсөлдөж байгаа, шударгаар өрсөлдөх гээд гэрээгээ байгуулаад явж байгаа

хүмүүс юм уу, нөгөө талд зөвхөн Саммитмедикал ХХК-ийн урьдчилгаа төлбөрийн мөнгөний асуудал юм уу.

Нөгөө талаас өнөөдөр мөн энэ компани дахиад л өрсөлдөөд явж байгаа. Тэгэхээр хохирол учирсан буюу шууд хохирол учирсан гэж ерөөсөө харагдахгүй байна. Эсрэгээрээ эдний компанид нөхөж болшгүй гарз тохиочихсон бол захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх энэ зарчим үйлчилж болох юм. Тэгэхэд нөхөж болох мөнгөөр хэмжигдэх боломжтой иргэний журмаараа гэрээний урьдчилгаа төлбөрийг шаардах эрхийн зарчмаар шаардаад буцаагаад авчихаж болно гэсэн үг.

Тэгэхлээр маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг шийдвэрлэж үзэхдээ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62.1.1 дэх заалтад заасан захиргааны актыг түдгэлзүүлж болохгүй нөхцөлийг харгалзан үзээд бодит байдал дээр түүний яг ямар эрх, ашиг сонирхол нь хууль ёсны байх шаардлагад нийцсэн байх ёстой юм бэ? Захиргааны шүүхийн үндсэн зарчим нь өөрөө зөрчигдсөн эрхийг сэргээдэг, хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээдэг. Тэгтэл "Саммитмедикал" ХХК-ийн хувьд өнөөдөр тендертээ ороод явж байна. Зөвхөн гүйцэтгэлийн, урьдчилгаа төлбөрийн баталгаа дээрээ ингээд явж байгаа тохиолдолд иргэний хэргийн маргаанаар хэргийг шийдвэрлүүлээд цаашаа үргэлжлүүлэх бүрэн боломжтой байна гэж үзэж байна. Эдгээр нөхцөл байдлуудыг харгалзаж үзээд маргаан бүхий захиргааны актыг түдгэлзүүлэх хүсэлтийг хангахгүй шийдвэрлэж өгнө үү гэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Маргаан бүхий захиргааны актаар, Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажлын ДГАНЭ/202311005 дугаартай тендер шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зарлажээ.

Нэхэмжлэгч "Саммитмедикал сервис" ХХК-иас хариуцагч Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн дээрх шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүсэлт гаргаж үндэслэлээ: "...2024 оны 03 сарын 26-ны өдөр тендерийн гүйцэтгэлийн баталгаа 83,400,000 төгрөгийг Худалдаа хөгжлийн банканд байршуулсан, ...тендерийн гүйцэтгэлийг түргэн шуурхай гүйцэтгэхийн тулд үйлдвэрлэгч PHILIPS компани руу компьютер томографын аппаратын үйлдвэрлэлийг эхлүүлэх зорилгоор мөн өдөр урьдчилгаа төлбөр 33,130.50 еврог шилжүүлж аппаратын үйлдвэрлэлийг эхлүүлсэн. Нэгэнт үйлдвэрлэл эхэлсэн тул урьдчилгаа төлбөрийг буцаан авах боломжгүй нөхцөл байдал үүсэж бидний эрх, ашиг хөндөгдөж, санхүүгийн эрсдэлд орох нөхцөл байдал үүссэн. Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгээс, компьютер томографын аппарат худалдан авах тендер шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дахин зарласан шалгаруулалтын ажиллагаа үргэлжилж 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр нээхээр цахим хуудаст мэдээлэл орсон байна. Хэрэв тендер сонгон шалгаруулалт явагдсан тохиолдолд манай компанийн тус шүүхэд нэхэмжлэл гарган маргаж буй асуудал ач холбогдолгүй болох бөгөөд манай компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхол сэргэх боломжгүйд хүрэхээр байна. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал байхгүй байна" хэмээн тайлбарлаж байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.-д “Энэ хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ”, 62 дугаар зүйлийн 62.1-д “Захиргааны актын биелэлтийг дараах тохиолдолд түдгэлзүүлж болохгүй: 62.1.1.захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээд эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар бол; хэмээн заажээ.

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж хэрэгжилтийг түр зогсоох нь шүүхээс маргааныг эцэслэн шийдвэрлэж дуусах хүртэл нэхэмжлэгчид эрх зүйн түр хамгаалалт тогтоох улмаар маргаж буй шийдвэрийн хэрэгжилтээс үүсэж болох сөрөг үр дагавраас хамгаалахад чиглэгддэг.

Хэрэгт авагдсан нотлох баримтууд болон хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч нарын шүүхийн хэлэлцүүлэгт гаргасан тайлбар зэргээр “Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажил”-ын ДГАНЭ/202311005/01/01 дугаартай тендер шалгаруулалтыг 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр анх зарласан, тус тендер шалгаруулалтад гуравдагч этгээд “Сетунари” ХХК-ийн тендер хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарснаар, захиалагч тухайн компанид “Гэрээ байгуулах эрх олгох тухай”, нэхэмжлэгч “Саммитмедикал сервис” ХХК-д шаардлагад нийцээгүй талаарх мэдэгдлийг тус тус хүргүүлсэн, улмаар “Саммитмедикал сервис” ХХК-иас захиалагчийн эдгээр шийдвэрүүдэд холбогдуулан Сангийн яаманд гомдол гаргаснаар тус яам захиалагчийн тухайн шийдвэрүүдийг хүчингүй болгож, тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг дахин зохион байгуулахыг мэдэгдсэн,

Захиалагч нь Сангийн яамны дээрх шийдвэрийн дагуу тухайн тендерт дахин үнэлгээ хийж, нэхэмжлэгч “Саммитмедикал сервис” ХХК-ийн тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгаруулан тус компанид “Гэрээ байгуулах эрх олгох тухай” мэдэгдлийг, гуравдагч этгээд “Сетунари” ХХК-д шалгараагүй талаарх мэдэгдлийг тус тус хүргүүлсэн, улмаар гуравдагч этгээд “Сетунари” ХХК-ийн зүгээс захиалагчийн эдгээр шийдвэрүүдэд холбогдуулан Сангийн яаманд гомдол гаргаснаар, тус яам захиалагчийн тухайн шийдвэрүүдийг мөн хүчингүй болгосон,

Улмаар нэхэмжлэгч “Саммитмедикал сервис” ХХК-иас, Сангийн яамны дээрх шийдвэртэй маргаж шүүхэд нэхэмжлэл гаргаснаар, Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажлын ДГАНЭ/202311005/01/01 дугаартай тендер шалгаруулалттай холбоотой маргаан Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хянагдаж байгаа,

Түүнчлэн захиалагч Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгээс 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр “Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажил”-ын ДГАНЭ/202311005/02/01 дугаартай тендер шалгаруулалтыг зарласан, “Саммитмедикал сервис” ХХК-иас тухайн шийдвэрт холбогдуулан тус шүүхэд нэхэмжлэл гаргаснаар, “Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажил”-ын ДГАНЭ/202311005/02/01 дугаартай тендер шалгаруулалттай холбоотой маргаан тус

шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа бөгөөд уг тендерийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 10:00 цагт нээхээр зарласан үйл баримтууд тус тус тогтоогдож байна.

Нэхэмжлэгч хуулийн этгээдийн хүсэлтийн үндэслэлд дурдагдсан "Гэрээ байгуулах эрх олгосон захиалагчийн шийдвэртэй холбогдуулан тендерийн гүйцэтгэлийн баталгааг байршуулсан, компьютер томографын аппаратын үйлдвэрлэлийг эхлүүлэх зорилгоор урьдчилгаа төлбөр шилжүүлсэн" гэх асуудал нь хэдийгээр "Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажил"-ын тендер шалгаруулалттай холбоотойгоор нэхэмжлэгч хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн үйлдэл байх боловч энэ нь маргаан бүхий захиргааны акттай шууд шалтгаант холбоогүй бөгөөд тухайн захиргааны акт хэрэгжсэнээр нэхэмжлэгч хуулийн этгээдэд илт хохирол учруулах үр дагавартай гэж үзэх боломжгүй байна.

Тодруулбал, нэхэмжлэгч нь "тендерийн гүйцэтгэлийн баталгааг байршуулсан, компьютер томографын аппаратын урьдчилгаа төлбөр шилжүүлсэн" үйл баримтаа "Гэрээ байгуулах эрх олгох тухай" захиалагчийн шийдвэртэй холбон тайлбарладаг бөгөөд тэрээр энэхүү шийдвэрийг нь эрх бүхий этгээдээс хүчингүй болгосонтой холбоотой тусдаа маргаж, уг маргаан Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа нөхцөлд, "төлбөрийг буцаан авах боломжгүй нөхцөл байдал үүсэх, эрх, ашиг нь хөндөгдөх, санхүүгийн эрсдэлд орох нөхцөл байдал үүссэн" хэмээн маргаан бүхий захиргааны актын хэрэгжилттэй холбон тайлбарлаж буй нэхэмжлэгчийн тайлбарыг хүлээн авах үндэслэлгүй гэж үзэв.

Хариуцагчаас, "Саммитмедикал сервис" ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон захиалагчийн шийдвэрийг Сангийн яамны 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 03/2353 дугаар шийдвэрээр хүчингүй болгосон бөгөөд Сангийн яамны энэ шийдвэр хүчингүй болсон тухай аливаа шийдвэр, мэдэгдэл бидэнд ирээгүй, энэ шийдвэр хүчин төгөлдөр байна, нэхэмжлэгч нь 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр тендерийг дахин зарласантай холбоотой эрх, ашиг хөндөгдсөн гэж тендер шалгаруулалтыг зогсоолгох хүсэлт гаргасан нь үндэслэлгүй" гэж,

Гуравдагч этгээдээс "Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ гэдэг хүний эрүүл мэнд, амь настай холбоотой, нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлж болох, хохирол учруулж болох ийм нөхцөл байдал учраас нийтэд илтэд хохиролтой зүйлийг зогсоохоор нэхэмжлэл гаргаж байгаа нь өөрөө үндэслэлгүй, ... нэхэмжлэгчийн хүсэлт нь хууль зүйн үндэслэлгүй, өөрийнх нь эрх, ашиг хөндөгдөөгүй, одоо ч өөрөө үргэлжлүүлээд тендерт ороод явж байгаа. Эсрэгээрээ энэ актын биелэлтийг түдгэлзүүлэх тохиолдолд аймгийн хүн ам, иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээ авч чадахгүй, хор хохирол учруулахаар, нийтийн эрх, ашиг сонирхол хөндөгдөхөөр байгаа" гэх зэрэг тайлбарыг тус тус гаргаж мэтгэлцсэн боловч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1-д заасан "захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулах"-аар үндэслэл тогтоогдохгүй байна гэж үзэв.

Нөгөөтэйгүүр нэхэмжлэгч “Саммитмедикал сервис” ХХК нь “Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах” тендерт өмнө нь шалгарч байсан улмаар ийнхүү шалгарсан талаарх шийдвэрийг нь эрх бүхий байгууллагаас хүчингүй болгосонтой холбогдуулан маргасан байх бөгөөд уг маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа энэ тохиолдолд тухайн тендерийг буюу “Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах” тендерийг дахин зарласан шийдвэрийн нэхэмжлэгчид хамааралгүй гэж үзэх боломжгүй тул энэхүү хэргийг шийдвэрлэх хүртэл нэхэмжлэгчид эрх зүйн түр хамгаалалт зайлшгүй шаардлагатайг үгүйсгэхээргүй байна.

Түүнчлэн маргаан бүхий захиргааны акт нь 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр гарсан шийдвэр байх боловч тухайн шийдвэрээр 2023 оны 12 дугаар сард анх зарласан “Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажлын ДГАНЭ/202311005 дугаартай тендер”-ийг дахин зарласан байх ба энэ тохиолдолд тус тендерт оролцогчдын хэн аль нь энэхүү тендер шалгаруулалттай холбоотой захиалагчийн шийдвэрт хуульд заасан эрхийнхээ хүрээнд гомдол гаргах боломжтой ба,

Дээрхээс үзэхэд маргаан бүхий захиргааны актыг түдгэлзүүлэхгүй орхисноор (тухайн захиргааны акт хэрэгжсэнээр) нэгэнт маргаантай байгаа “Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажил”-ын тендер шалгаруулалт улам удаашрах, цаашид маргаан өргөжих нөхцөл байдал бий болж болох бөгөөд улмаар энэ нь хариуцагчийн тайлбарт дурдсанчлан “аймаг орон нутагтаа компьютер томографын оношилгоо хийлгэх боломжгүй, иргэдийн эрүүл мэнд, амь нас зэрэг нийтийн эрх ашиг сонирхлыг хохироохуйц сөрөг үр дагавар бодитоор бий болгох”-ыг ч үгүйсгэх боломжгүй байна.

Иймээс, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажлын ДГАНЭ/202311005 дугаартай тендер шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дахин зарласан хариуцагч байгууллагын шийдвэрийн биелэлтийг хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл түдгэлзүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Шүүгчийн захирамж, тогтоолд гомдол гаргах эсэх талаар зохицуулсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д “Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн ... 61.1, ... дахь хэсэгт заасан ... шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд бичгээр гарсан өдрөөс нь хойш долоо хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.” хэмээн заасан байх боловч мөн хуулийн 122 дугаар зүйлийн 122.4-т “Энэ хуулийн ... 112.4-т заасан маргааны хувьд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсанаас бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргах шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргахгүй” хэмээн тусгайлан зохицуулсан байна.

“Саммитмедикал сервис” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт холбогдох энэхүү захиргааны хэрэг нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.4.2-т зааснаар тусгай журмаар шийдвэрлэх маргаанд хамаарах тул энэхүү маргааны хянан шийдвэрлэх

ажиллагааны явцад гаргасан шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй болохыг дурдах нь зүйтэй байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1-д заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч “Саммитмедикал сервис” ХХК-ийн хүсэлтийг хангаж, Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгээс “Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажил”-ын ДГАНЭ/202311005/02/01 дугаартай тендер шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зарласан шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлсүгэй.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.3-т зааснаар захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн шүүгчийн захирамж нь тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хүчин төгөлдөр байхыг дурдсугай.

3.Шүүгчийн захирамжийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид танилцуулж, баримтжуулахыг шүүгчийн туслах Ц.Тэгшдүүрэнд даалгасугай.

4.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.4-т зааснаар энэхүү шүүгчийн захирамжид гомдол гаргахгүйг дурдсугай.

ШҮҮГЧ



Б.СИЙЛЭГМАА